

ЗӨВЛӨХИЙН ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 07-р сарын 03

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газар нь “Суманд хатуу хучилттай засмал зам тавих зураг төсөв боловсруулах ажил ГСАШГСЗДТ/201912008” хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хураангуй жагсаалтад багтсан дараах зөвлөхүүдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

- “Тарваченбүүлэн” ХХК
- “Танил санаа” ХХК
- “Кадсүрвэй” ХХК
- “Дөрвөн тэнхлэг” ХХК

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн энэхүү зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон **хосолмол үнэлгээний** аргад үндэслэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоно.

2. Зөвлөхийн саналын урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй байна. Үүнд:

Бүлэг 1 - Урилга

Бүлэг 2 - Зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгаа (Тендерийн өгөгдлийн хүснэгтийн хамт)

Бүлэг 3 - Техникийн санал - жишиг маягт

Бүлэг 4 - Санхүүгийн санал - жишиг маягт

Бүлэг 5 - Ажлын даалгавар

Бүлэг 6 - Гэрээний жишиг маягт

Бүлэг 7- Тендерийн баталгаа /Хэрэв шаардсан бол/

3. Энэхүү баримт бичгийг хүлээн авсан тухай албан ёсоор мэдэгдэнэ үү.

Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг,
Нутгийн удирдлагын ордны 2-р давхар 208 тоот өрөө
Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар
Утас: 70546204, 99038561 email: shiveegovi.investment@gmail.com